

ХОРЬДУГААР ЗУУНЫ МОНГОЛЫН НИЙГМИЙН ДАВХРААЖИЛ

Х.Гүндсамбуу
Социологийн шинжлэх ухааны доктор (ScD)

Асуудлыг дэвшүүлэхүй. Хорьдугаар зууны монголын нийгэмд шашны болоод иргэний, колони атлаа холбооны, тусгаар мөртлөө автономи, уламжлалт хэрнээ орчин үеийн, Төв азийн зулайг эзэлсэн хэрнээ хот улс шиг, дагуул хийгээд жийргэвч, нэгдмэл гэтэл хуваагдмал, нэг улс атлаа нүүдлийн болон суурин иргэншил хосолмол, дорно дахины мөртлөө барууны маягийн, мал аж ахуйн байтлаа үйлдвэржсэн, хувьсгалын ба шинэтгэлийн гэсэн тодотгол, зүүлт тохирно, нийцнэ хэмээвэл дэндсэн дэвэргэл болохгүй. Монголын нийгэм үнэхээр олон тал, талст, ирмэг, хажуутай. Энэ бүхэн нь харийн эрхшээл, эзэрхийллээс тусгаар тогтносон бүрэн эрхт улсад, нүүдлийн феодализмаас социалист байгуулалтад, өнөөгийн ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих түүхэн гурвал шилжилтээр нөхцөлдсөн юм. Тийм болохоор гадныхан төөрөлддөг, андуурдаг, эндүүрдэг, өөрийнх нь будилдаг, ташаардаг.

XX зууны монголын түүхэнд эгзэгтэй, эмгэнэлтэй, эргэлтийн шинжтэй агаад өгсөлт уруудалтын аль аль нь тохиосон. Тиймээс XX зууны Монгол улиран одсон буурал түүхийн дурсгал төдий биш өнөөдрийн биелэл, ирээдүйн залгаас тул үлдсэн түүхээсээ сургамж авахад ч угтал түүхээ төсөөлөхөд ч онцгой ач холбогдолтой.

XX зууны Монголын нийгэм бол нийгмийн шинжлэх ухааны танин мэдэхүйн гайхамшигт лаборатори бөгөөд түүнийг танин мэдэх, судлан шинжлэхээр манай эрдэмтэд судлаачид өрнө, дорнын суут сэтгэгчид, шинжлэх ухааны шилдэг төлөөлөгчдийн онол, үзэл баримтлал, арга зүйг ашиглан гарааны зурхайгаас хөдөлж, үнэний мөрийг хөөхдөө олсон нь их ч, бас будилж төөрөлдсөн нь бий.

Манайхны сайн гадарлах, тааруухан доторлох К.Марксын сургаалын формацийн онол, ангич хандлагыг түлхүү барьж, Азийн үйлдвэрлэлийн арга, соёл иргэншлийн хандлага, өв санг орхигдуулснаа одоо түүнийг үнэлэхээсээ ад шоо үзэх нь илүүтэй болжээ. Угтаа марксизмын ачаар манайхан эх түүх, амьдран буй нийгмээ бурхны тааллаар бус, шинжлэх ухааны үүднээс танин мэдэх үүд нээгдсэн. Түүнийг ленинч ёсоор коммунистчилж сталнич аргаар “робинзон крузочилж” брежневч арга барилаар зогсонги байдалд оруулж, горбачевч маягаар өөрчлөн байгуулснаар, нэг талаас Марксын үзэл санаа танигдахын аргагүй болсон, нөгөө талаас түүний онол цагийн аясаар хуучирсан нь үнэн. Гэхдээ манайхан түүний бүтээлээс номын сангаа зайчилж байхад, өрнөдийн шилдэг сурах бичгүүдэд байраа эзэлсээр л байна. Яагаад гэвэл тэр нь шинжлэх ухаан-танин мэдэхүйн хувьд үнэ цэнэтэй хэвээрээ байна.

Ерөөс монголын нийгмийн судалгаанд ганцхан марксизм буруутай юмуу хүчин мөхөсдөж байгаа юм бишээ. Өнөөдрийн өдөр, шилжилтийн жилүүдэд гэхэд ажилгүйдэл, дотоодын нийт бүтээгдэхүүний хамаарлыг үзүүлдэг Оукены хууль, түүнийгээ дагаад Филипсийн муруй гажсан байдалтай байна. Энэ бол тухайн тохиолдол байж болох юм. Түүнээс гадна хөгжлийн эдийн засгийн онолч А.Льюсийн хоёр секторын онол тонгоруу байдлаар илэрч байгаа. Энгийн жишээ татахад 1989 онд 68.9 мянган өрхийн 135.4 мянган малчин манай улсын хүн амыг мал аж ахуйн бүтээгдэхүүнээр, хөнгөн хүнсний үйлдвэрийг түүхий эдээр, экспортыг тодорхой нөөцөөр өлхөн хангаж байсан бол одоо мал аж ахуйд 268.7 мянган өрхийн 421.4 мянган малчин ажилдаг болов.⁵³ Өөрөөр хэлбэл шилжилтийн жилүүдэд мал сүргийн хувьчлалыг дагалдан хөдөө аж ахуйн нэгдэх сектороос аж үйлдвэрийн хоёрдох юмуу үйлчилгээний гуравдах сектор руу бус, харин хоёрдох сектороос нэгдэхрүү юүлэгдэж байгаа нь тухайн тохиолдол уу эсхүл Льюсийн онолын гажуудал уу?

⁵³ Монгол улсын статистикийн эмхэтгэл 2000. УБ.2001, 133 дахь тал⁵³

Энд бас А.Льюсийн онолын эдийн засгийн тал нь төдийгүй, улс төрийн тал нь ч ихээхэн сонирхол татаж байна. Олон бүрэлдэхүүнт нийгмийн нэгдэхүйн⁵⁴ ардчилалын онолч А.Лейпхарт, А.Льюсийн хөгжлийн эдийн засгийн хоёр секторт онол нь сонгодог гэхээсээ нэгдэхүйн ардчиллын эрх ашигт шаггүй нийцэж буйг цохон тэмдэглэсэн юм. Тэгвэл өнөөгийн монгол сонгодог ардчиллыг шууд хүлээж авах уу? тийм чадвар, чадавхтай юу? эсхүл арай доод эрэмбийн нэгдэхүйн ардчиллыг хүлээн авах уу? гэдэг тун нарийн асуудал. Өнөөгийн монгол төрийн байгууламжийн хувьд яахын аргагүй нэгдмэл нэг улс. Харин нүүдлийн ба суурин иргэншил зэрэгцэний хувьд хоёр бүрэлдэхүүнт, олон хэсэглэл бүхий улс яахын аргагүй болчихоод байна. Ийм улсад барууны сонгодог ардчилал бус, харин арай энгийн эгэлдүү, хамгийн гол нь үндэсний эрх ашгийг дээдэлсэн нэгдэхүйн ардчиллыг хүлээн авч, түүгээр дамжин сонгодог ардчилалд дэвшин шилжиж магадгүй. Гэтэл манай улс төрчид нэгдэхүйн ардчиллыг мэддэггүй юмуу тоодоггүй юмуу сонгодог ардчилал руу хошуурч, түүнийг хөгжүүлэхээсээ хуулбарлаж байгаа нь коммунизмаас дутахааргүй туршилт ч болж мэднэ. Ардчиллыг олон ургалч үзлийн үүднээс бус, аль нэгийг нь туйлчлах явдал ардчилалд хүрэх бус харин ч ухралт болох аюултай. Үүнд улс төрчид бус, түүх л хариулт өгнө.

Монгол улсын шинэ Үндсэн хуулинд зааснаар “эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх эрхэм зорилго”⁵⁵ бодит биелэлээ олох амин чухал нөхцөл бол ангиудад зохиомлоор хуваагдмал бус харин жам ёсоороо давхраажих нийгэм байгуулах явдал мөн. Монголын нийгмийн өнгөрсөн түүх ч, хөгжлийн ирээдүй ч өөрийнхөө язгуур үндэс болсон хүнээс, “хүн-капиталаас”, хүмүүнлэгийн нийтлэгүүдээс, нийгмийн бүлэг давхраанаас, бүхэлдээ ард түмнээс шалтгаална. Захиргаадлын жилүүдэд нийгмийн асуудалд зөвхөн ангийн, бүр тодруулбал ажилчин ангийн үүднээс хандаж байснаас манай нийгмийн бүтэц гажуудалд орж, уугуул зүй тогтлоосоо хазайсан. Тэр нь одоогийн шилжилтийн үед улам тодорхой болж, дунд анги, дунд давхрааны давамгайлал руу гэхээсээ хоёр туйлруугаа заагарч, тэгэхдээ ядуурал ажилгүйдэл рүү гулсаж байна. Ийм учраас монголын нийгмийг ангийн бүтцийн үүднээс биш давхраажлын үүднээс судлан шинжлэх зайлшгүй шаардлагатай. Ёийгмийн энэхүү захиалгад чадлынхаа хэрээр боломжийн хариу өгөхөд тус бүтээл зориулагдсан болно.

Судалгааны объект XX зууны Монголын нийгмийн бодит байдал бөгөөд түүний өөрчлөлт, хувьсал эргэлтүүд болно. Судалгааны объект нь нэн өргөн хүрээтэй, олон талтай болохоор тус ажлын зорилго, зорилтуудад захируулан, зохих хязгаарлалт хийсэн болно.

Судалгааны судлах зүйл бол XX зууны Монголын нийгэмд байсан үүсэн төлөвшсөн, бас цаг бусаар хэлмэгдсэн хийгээд шинээр төрж байгаа давхраанууд бөгөөд тэдгээрийн нийгмийн орон зай, цаг хугацаа, нөхцөл байдал, харилцан шүтэлцээнд нь авч үзэх явдал мөн.

Сэдвийн судлагдсан хэр зэргэмж Хоёр зууны төдийгүй, хоёр мянганы заагт манай эрдэмтэн мэргэд монголын нийгмээ, удам судраа, угшил түүхээ бүхэлд нь XX зууныхныг жичид нь сонгодог онол, шинэлэг арга зүйгээр ирмүүхэн судлаж, шинэ сонин бүтээл туурвилынхаа дээжсийг нийтийн хүртээл болгож эхэллээ. Тэдгээрээс жирмийн сүлжээс болгон төлөөлүүлбээс:

Манай нийгмийн ухааны магнайд түүх судлал явж ирсэн уламжлалаа⁵⁶ дагаад ч сүүлийн жилүүдэд ахмад болон залуу судлаачдын нэлээд бүтээл хэвлэгдэв. Байцаас үзэхэд миний төсөөллөөр түүх бичлэг, судлалд ерөнхийдөө хоёр хандлага үүсэн тэрэлж байгаа бололтой. Нэг дэх нь гэвэл мэргэжлийн түүхчид эх түүхээ түүхэн үнэнээр нь сэргээхийг хичээж, доголдсон орхигдсон, дарагдсан, танагдсан, мартагдсан, нууцлагдсан зүйлсийг түүхийн сурвалж судалгаагаар амилуулан

⁵⁴ “Сообщественная демократия” гэдгийг нэгдэхүйн ардчилал хэмээн оноон орчуулахад сэтгэлд буухгүй тал бий. Гэвч үндэсний хийгээд шашны олон бүрэлдэхүүнт нийгэмд сонгодог бус нэгдэхүйн ардчилал хөгжиж буйг америкийн улс төр судлаач А.Лейпхарт. “Олон бүрэлдэхүүнт нийгэм дэх ардчилал: харьцуулсан судалгаа” (М., 1998) сонгодог бүтээлдээ тов тодорхой нотолсон юм.

⁵⁵ Монгол улсын хууль. УБ., 1992.3 дахь тал

⁵⁶ Л.Бат-Очир. Ард анги: бүтэц, өөрчлөлт хоршоожилт УБ., ШУАХ, 1984; Д.Гонгор. Халх товчоон. I, II УБ., ШУАХ, 1979. 1983; Н.Жагварал. Аратство и аратское хозяйство. УБ., Издво АИ МИФ. 1974; Ц. Насалбалжир. Ар Монголоос Манж чин улсад залгуулж байсан алба. 1691-1911. УБ., ШУАХ, 1964; Ш.Нацагдорж. Монголын феодализмын түүхэн замнал. УБ., УХГ. 1978 г.м

нийгэм судлалын эргэлтэнд оруулан уншигч таны оюуны цангааг тайлж байна.⁵⁷ Нөгөө дэх нь монголын шинжлэх ухааны академийн гадаад хүндэт гишүүн, Олон улсын монгол судлалын холбооны анхны ерөнхийлөгч агсан О. Латтиморын “дагуул” монголыг “жийргэвч бүсээр” сольж, өнгөрсөн түүхийг зөвлөлт-оросын эсрэг арга зүйгээр, улс төрийн учир шалтгаанаар дахин бичиж буй түүх сонирхогчид бөгөөд тэд Эдүгээ “хэтэрхий мэргэн жараахайгаар” тодорч байна.⁵⁸ Тэд түүх судлалд шинэ сэргэг баримт, хандлага авчрахын сацуу зарим нь түүхийг дахин түүхийрүүлсэн ч, түүхэн үнэнийг сэргээхийн оронд түүхэн зүхэл болгосон ч, үндсэн мэргэжлээ гээж, шинээр түүхч болсон ч үзэгдэнэ.

Манай философичид сүүлийн үед өрнөдрүү цаашлахын хамт дорно дахины өв сан руугаа эргэж, өрнө дорны сэтгэгчдийн солбицол дээр нийгмээ судлаж, нүүдэлчдийн нийгмийн байгуулал, нийгэм-ангийн бүтэц, соёл, иргэншил, гүн ухааны сэтгэлгээний түүх, буддизм судлалаар дориун бүтээлүүд нийтлэгдэв.⁵⁹ Мөн түүнчлэн Эдүгээ цагийн нийгмээ олон ургальч үзлээс улбаалан “нэг улс-хоёр иргэншлийн” цонхоор харсан⁶⁰ байхад “их гурвалжинд” багтаан “зэндмэний” хийгээд “хаан философийн” эрэл хайгуулд мордсон ч байна.⁶¹

Дотоодын Монгол судлалд сүрхий ахиц гарлаа. Нүүдэлчдийн нийгэм, бөөгийн ба буддын шашин, Монголчуудын бэлгэдэл, үнэт зүйлс, төр-шашны түүхэн зүтгэлтнүүд, монгол туургатны түүх, соёлын сан хөмрөг зэрэг нь эрдэм судлалын ажлын талбайд орж ирлээ.

Монголын нийгмийн шинжлэх ухааны ам бүлд социологийн шинжлэх ухаан багтан орж, хойморт нь биш юмаа гэхэд байраа эзэлж, суудлаа засав.¹⁰ Эдгээр болон түрүүчийн тогтолцооны үеийн шилдэг бүтээлүүд нь¹¹ горилогчид шинэ сэргэг санаа оноо, урам зориг хайрлав.

Судалгааны зорилго, зорилтууд, Шийдвэрлэх асуудлын боловсруулалт, шинэлэгийг харгалзан, өнгөрсөн нэгэн зууны монголын нийгмийн давхраажлыг социологийн үүднээс шинжлэн судлахыг зорилгоо болгов.

Судалгааны явцад дараах зорилтуудыг гүйцэлдүүлэхийг хичээв. Үүнд:

- Монголын нийгмийг давхраажлын онол-арга зүйн үүднээс судлах;
- Хорьдугаар зууны монголын нийгмийн үндсэн давхраануудын нийгмийн хөргийг нийгмийн бүтэц, давхраажил, түүхэн социологи зэрэг социологийн салбар ба тусгай онолын төвшинд зураглах
- Уламжлалт ба шинэхэн анги, давхрааны үүсэл, төлөвшил, өөрчлөлт, хувь тавиланг тодруулах, дахин шинээр үнэлэх
- Шилжилтийн үеийн нийгмийн давхраануудын сэргэлт, үүсэл, төлөвшил, ойрын ирээдүйг тодорхойлох зэрэг болно.

Судалгааны онол-арга зүйн үндэс нь дэлхийн социологийн сэтгэлгээний сонгодог төлөөлөгч Ө.Маркс, М.Вебер, П.Сорокин нарын суурь бүтээл, тэдний шинжлэх ухааны сургууль, чиглэл, үзэл

⁵⁷ Монгол улсын түүх (Түүх, онол аргагүйн асуудлууд) УБ., 1999: Л.Бат-очир. Халхын хаадын төгсгөл УБ., “Согоо нуур”. 2001: Ж.Болдбаатар. Д.Лүндэжжанцан. Монгол улсын төр. Эрхзүйн түүхэн уламжлал. УБ., “Адмон”. 1997: Л.Мөнх-эрдэнэ. Түүхийн гүн ухааны лекцүүд. УБ., 2000 г.м

⁵⁸ Баабар. XX зууны монгол: нүүдэл суурьшил. Олз гарз. УБ., 1990

⁵⁹ Монголын философийн түүх. I-VI дэвтэр. УБ., 1998-2001; Н. Хавх Нийгмийн гүн ухаан. УБ., 1996: Ц.Гомбосүрэн. Нийгмийн философийн интеграль (нэгдгэгч) хувилбарыг боловсруулах эхлэл. УБ., 1999: Б.Даш-Ёндон. Төв үзэл сэтгэх арга, ажиглалт, бодрол. УБ., “Уриа”, 1995: Монголын төрийн байгуулал, улс төрийн сэтгэлгээний хөгжил. (МЭӨ-МЭ XX зуун). Хоёр боть УБ., “Эрдэм” 1995 г.м,

⁶⁰ Г.Чулуунбаатар. XX, XXI зууны зааг үеийн Монгол дахь иргэний нийгмийн төлөвшил хөгжил. УБ., 1999.

⁶¹ Ч.Эрдэнэ. Их гурвалжин: угшил ба оргил (тайллууд) УБ., 2000; П.Давааням. Суваргын онол (төрийн тэргүүн буюу хаан философи) УБ., 1996; “Бодь сэтгэл, эв хамт ёс” ганцаарчилсан хөдөлгөөний улс төрийн үзэл онол “Очир” үнэнээс цогцолсон Зэндмэнэ. УБ., 2000 г.м

⁸ Монгол улсын соёлын түүх. I-III боть. УБ., 2000: Г.Мэнд-Ооёо. Билгийн мэлмий нээгч. УБ., 1997; Б.Сумъяа. Монголын нүүдэлчдийн соёл орших эс ор орших. УБ., 2001; Д.Цэдэнсодном. Монголын бурхан шашны уран зохиол. УБ., “T&U printing”, 1997

¹⁰ БНМАУ-ын нийгмийн социалист харилцааны хөгжилт. УБ., ШУАХ, 1983: БНМАУ-ын нийгмийн бүтэц. УБ., ШУАХ. 1984; Ажилчин анги, хоршооллосон малчдын нийгмийн зарим асуудал. УБ., 1988; Өнөөгийн сэхээтний нийгмийн бүтэц. УБ., ШУАХ, 1987; Нийгмийн шинэчлэл: Амьдралын хэв маягийн өөрчлөлт. УБ., 2001;

¹¹ Ч.Жүгдэр XIX-XX зууны зааг дахь Монголын нийгэм улс төр, философийн сэтгэлгээний хөгжил. УБ., ШУАХ, 1972: С.Норовсамбуу. Капитализмын өмнөх харилцаа ноёрхож байгаа орнуудад ялсан социалист хувьсгалын харьцаа ба онцлогууд. УБ., 1965; П.Лувсандорж. БНМАУ-ын эдийн засгийн хөгжлийн зангилаа асуудлууд. УБ., 1980; Жагварал Н. Араство и хозяйство. Изд-во АН МНР, 1972:

баримтлалууд байв. Мөн бүтэц-үүргийн, системийн, иргэншлийн, диалектикийн болон синергетикийн хандлагыг хэр чинээгээрээ ашиглахыг зорьсон болно.

Судалгааны эх сурвалжууд гэвэл:

- Монгол улсын хүн амын 1918, 1935, 1944, 1956, 1963, 1969, 1979, 1989 оны тооллогын дүн, 2000 оны тооллогын урьдчилсан дүн. Монгол улсын статистикийн газраас удаа дараа хэвлүүлсэн төрөлжсөн, сэдэвчилсэн, салбарласан, ойн эмхтгэлүүд.

- Зохиогчийн удирдсан ба зонхилон оролцсон социологийн томоохон судалгаануудын үр дүн, тайлан.

- Архивын болон албан хэрэгцээний зарим мэдээ сэлт зэрэг болно.

Зохиогч урьд нь энд тэнд хэвлүүлэн нийтийн хүртээл болгосон гэхээсээ сүүлийн жилүүдийн эрэл хайгуул, эрэгцүүлэл ухаарал, эрдэм судлалын ажлынхаа дээжийг сорчлон толилуулж буйгаа эрхэмсэг Уншигч авгай танд аминчлан хэлмээр байна.

Монголын нийгмийн давхраажлын судалгааны онол- арга зүйн зарим асуудал

Хорьдугаар зууны монголын нийгэм нэг талаас, түүхэн уламжлал, язгуур, унаган шинж төрх, гарвал зүйн кодуудаа хадгалан хөгжиж ирсэн, нөгөө талаас, замбуу тивийг хамарсан хувьсгалт үйл явц, дайн самуун, хэлмэгдүүлэлт, аж үйлдвэржилт, хот байгуулалт, шинжлэх ухаан - техникийн дэвшил зэрэгт хэр чинээндээ хөндөгдсөний хувьд харьцуулсан, зэрэгцүүлсэн, тухайлсан судалгааны сонин талбар, ургальч үзлийн гарааны зурхай билээ. ...Энэ зүйлд арга зүйн холбогдолтой зарим асуудлаар санал бодол, эрэгцүүлэл ухаарал юугаа өргөн толилуулахыг хичээв.

Дорно өрнийн, мөн дотоод гадаадын эрдэмтдийн бүтээл туурвил, мэргэдийн ном хаялцсан байцаас үзвэл монголын нийгмийн талаар бүхэлд нь, давхраажлын судалгаанд жичид нь холбогдохуйц арга зүйн асуудлыг доорх байдлаар багцалж болохоор байна. Үүнд:

Нэгдүгээрт: Монголын нийгэм бол хэзээнээс янагш нүүдэлчдийн нийгэм байсаар, үе улиран хөгжсөөр ирсэн жамтай, түүхэн замналтай. Энэ нь нийгмийн шинжлэх ухааны арга зүйн тавил, ойлголтуудыг нэгэн бодлын эргэлзээтэй, нөгөө бодлын сонирхол татам болгодог юм. Харин давхраажлын үүднээс сонирхоход тариачин хүн ургац ахиухан авбал талбайгаа өргөтгөж, улмаар залгамж үедээ өвлөх юм үлдээдэг бол нүүдлийн, мал аж ахуйн нийгэмд мал сүрэг дандаа хорогдож, хөрөнгийн хуримтлал бий болгодоггүй намхан давхраажилтай гэсэн санааг орчин үеийн Америкийн нэрт социологич Н.Смелзер сурах бичгийн түвшинд шамдуу нь аргагүй дурдсан байдаг. Гэхдээ ертөнцийн нөгөө талд Монголын нийгмийн агуулга, мөн чанар, бодит давхраажлыг тодорхой судалгаагүйгээр ойлгоно гэдэг юу л бол.

Орчин үеийн Монголын нэрт түүхч, академич Ш.Нацагдорж “Монголын феодализмын үндсэн замнал” хэмээх суурь бүтээлдээ “газар зүй, цаг уурын нөхцөл нь нүүдэлчдийг нэгэн хэвийн аж ахуй, нүүдлийн мал аж ахуйг дагнан эрхлэхэд хүргэсэн бөгөөд уул аж ахуй нь тэдний дунд ангиуд үүссэн хийгээд төр улс тогтох зэрэгт нь ул мөрөө үлдээсэн билээ. Соёл иргэншлийн эрт балчир эхэн үед байгаль, газар зүйн хүчин зүйлээс ихээхэн хараат байсан нь маргаангүй бөгөөд ер нь газар зүйн орчин нийгмийн хөгжлийн явцыг удаашруулах буюу түргэтгэх үйлдэл үзүүлдэгийг марксизм үгүйсгэдэггүй бөгөөд харин тэрхүү газар зүйн нөлөөлөл нь үйлдвэрлэлийн харилцаагаар дамжин явагдаж байжээ. Нэгэнт ийм болохоор нүүдэлчдийн нийгмийн хөгжлийн асуудлыг түүх, нийгмийн шалтгааны зэрэгцээгээр газар зүйн орчин, байгалийн нөхцөлийн үүднээс, тэгэхдээ газар зүйн детерменизмд хальтран орчихгүйгээр тайлбарлаж чадвал бид нүүдлийн нийгмийн олон асуудалд хариу олж чадах юм” хэмээн өгүүлжээ. Марксизм - ленинизм хуваарьгүй ноёрхсон, үзэл сурталын хүлэгдмэл нөхцөлд, тухайн цаг үеийн эрхээр буурал академич өөрөөр хэлж зүрхлэхгүй байсан нь ойлгомжтой. Тэгэхдээ газар зүйн нөхцөл, экологийн орчныг дөвийлгөн тавьж, “Азийн үйлдвэрлэлийн аргаар” дамжуулан, Монголын феодализмын түлхүүр асуудал, ужиг маргаан мэтгэлцээний бай болоод байсан, үйлдвэрлэлийн анхдагч хэрэгсэл нь мал уу? газар уу? гэсэн ацан шалааг нэг тийш болгож газар [бэлчээр] нь шийдвэрлэгч үүрэгтэй гэсэн байр сууринд сайх эрдэмтэн хүрч очжээ. Үзэл сурталын халуун тогоонд нухлуулж, баруун зүүн дээрээ гартлаа

дэндэгнэж, хал үзэж, хашир суусан хашир эрдэмтэн маань үнэхээр “газар зүйн детерменизмд хальтран орчихгүйгээр” ийм дөхөлт хийсэн үү эсхүл марксизмын ар хударгаар ийм байр сууринд хүрсэн үү гэдгийг сониучлан мөшгөхөд илүүдэх юун билээ.

Монголын бэлчээрийн мал ахуйн онцлогтой холбогдуулан, газарзүйн детерменизмын үргэлжлэл юмуу бие даасан хувилбар гэлтэй нэгэн сонин санааг эдийн засгийн шинжлэх ухааны доктор Г.Пүрэвбаатар гуай өгүүлэхийг чихээрээ сонссон, нүдээрээ уншаагүй. Тэрбээр эрдэм шинжилгээний нэгэн хурал дээр “Монголчууд бид цаг уурын рентээр амьдардаг” гэсэн торгон санааг хэлсэн юм. Иймэрхүү шинэлэг хандлага үүгээр зогсохгүй хүрээлэн буй орчноос хальж, неомандал, сансар хорвоод хүртэл гарсан нь бий. Философийн шинжлэх ухааны доктор Н.Хавх нэрт эрдэмтэн Л.Н.Гумилевын онолын мөхлөг санааг “Од гариг, орчин дэлхийгээс авсан амьдрах хүчин хэвийн хэмжээнээс багасахад амьд биетийн амьдрах чадвар доройтох, улмаар мөхөлд хүрч болох, хэвийн хэмжээнд байхад амьдралын явц, хөгжил жигд, түвшин байх, хэвийн хэмжээнээс давах, хэт давахад түүнийг тэнцвэртэй байдалд оруулах хуулийн үйлчлэлийн зайлшгүй шаардлагаар орчинтой тэнцэх, түүнийг өөрчлөн хувирган, идэвхтэй үрэлгэн тэмцлийн замд өөрийн эрхгүй ордог жамтай ажгуу. Амьдралын ийнхүү илүүдсэн хүчийг олж авсан амьтан, үндэстэн, угсаатан, улс гүрэн тооны хувьд хэдийгээр цөөн боловч бусдад дийлдэхийн аргагүй хүчийг олж, бусдыг ялан дийлж, ялан дийлэхийнхээ явцад илүүдэл хүч нь багасан багассаар хэвийн байдалд ордог учиртай. Гэхдээ тэрхүү амьдрах хүч, амьд биет, түүний дотроос хүмүүсийн зарим хэсэгт хэтэрсэн хэмжээгээр зарим хэсэгт ердийнхөөс доогуур хэмжээгээр тус тус өөр өөр орсноос, амьдрах хүч нь илүүдсэн буюу эрчимт хүмүүс [пассионари], уг хүч дутагдсан буюу аминч хүмүүс [субпассионари] гэсэн хоёр хэсэг хүмүүс хуваагдаж, тэдгээрийн хооронд өрсөлдөөн, тэмцэлдээн болж, нэг үгээр хэлэхэд диалектик зөрчил үүсэж, өрнөж, шийдвэрлэгдэж, улс үндэстэн, угсаатны эрт, эдүгээ, ирээдүйн түүх бий болсон, одоо ч, цаашдаа ч үргэлжлэх учиртай болой. Амьдрах хүчийг олж авах, тэр нь үйлчилж дуусах нь аль нэг улс үндэстний хувьд 1200-1500 жилд нэг удаа давтагдах зүй тогтолтой” хэмээн хураангуйлжээ. Түүндээ дөрөөлөн Н.Хавх Монголын нийгмийн түүхэн замналыг дараах байдлаар тодотгон лавшруулсан байна.

Тэр “Эрт эдүгээ үед Азид оршин суугчид газар зүйн орчноос хүрч ирдэг амьдралын тэр хүчинд орж, Азийн улс, угсаатнууд бүх талаар цэцэглэн хөгжиж, хүчирхэгжин дэлхийд Ази төвт соёл иргэншил удаан хугацааны турш тогтож иржээ. Энэ үеийн хүний нийгмийн соёл иргэншилд өнөөгийн Монголчуудын өвөг дээдэс болох Хүннүгийн эзлэх байр суурь өндөр байжээ. Манай он тооллын VIII зуунаас эхлэн Азийн угсаатнуудын амьдралын хүчин гудайлтын шатандаа орж, харин Европт бол уг хүчин ид эрчээ авч эхэлсэн байна. VIII-XI зууны хооронд 300 жилийн дотор Дорно зүгийнхэн амар жимэр болж, барууныхан эрчимт байдалд орсон тухай, Баруунд чухамдаа амьдралын хүчин сэргэлтийн үе бий болсон байхад, Дорно зүгийнхэн түүний эсрэг үйл явц болох гудайлтын шатнаас уруудалтын шат руу шилжих үед орсон тухай Гумелив өгүүлжээ. Энэ эрдэмтэн хүн төрөлхтнийг эргээд Ази төвт соёл иргэншилд орно гэдгийг ном бүтээлдээ шууд хэрэглээгүй нь учир шалтгаантай байж болох юм. Гэхдээ амьдралын хүчний түлхэлт 1200-1500 жилд давтагддаг зүй тогтолтой гэдэг түүний санааг эргэж бодоход тийм дүгнэлт аяндаа гарах биз ээ” гэсэн юм.

Ер нь Л.Н.Гумилевын онол нь шинжлэх ухааны үүднээс тун сонирхолтой юм. Тэрбээр ургамал, амьтан, хүн төрөлхтөн ялгалгүй нар, сансраас ирэх илч туяаг, мөн дэлхийн гүнээс радио идэвхт задралаар бий болох атомын хүчийг авч, тамир тэнхээлэг болдог гэсэн В.И.Вернадскийн үзэл баримтлалыг түүх, нийгмийн судалгаанд няхуур ашигласнаараа, хүрээлэн буйн орчин тухайн тохиолдолд нийгмийн хөгжилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдгийг нотлон, түүхэн материализмын хязгаарлалтыг давж, Монгол туургатны түүхийг өөрөөр тайлбарласнаараа онцлог юм.

Сүүлийн үед залуу эрдэмтэн Б.Гантөмөр монгол нүүдэлчдийн нийгмийн байгууллын онцлогийг:

1. Монголын уламжлалт нийгмийн төрөлх шинж нь хүн байгалийн зохистой хослол,
2. Газар зүйн өвөрмөц орчин мал сүргийг адгуулах бэлчээрийн зайлшгүй шаардлагаар нөхцөлдсөн нийгмийн байгууламжийн анхдагч дэд тогтолцоо хот айл,
3. Уламжлалт нийгэм, нүүдлийн иргэншлийн маш чухал талын нэг нь хүмүүсийн тулсан харилцаамж бөгөөд түүнд зөвхөн хүний бодгаль, амин шинж давамгайлдаг,
4. Бусад нүүдэлчин ард түмний нэгэн адил хүмүүсийн хоорондын

харилцааны ёс зүйн хэм хэмжээний үндэс нь ахмаддаа шүтэн захирагдах ёс байдаг гэж бичсэн нь анхаарал татаж байна.

Хоёрдугаарт, Монголын нийгмийн байгууллыг “Феодалын байгуулал”, “Феодализм” мөн эсэх талаарх эрдэм шинжилгээний эрэл хайгуул нь арга зүйн нэлээд төвөгтэй асуудлыг дэвшүүлэн тавьж байгаа юм. Энэ нь Монголын нийгмийн түүхийн өнгөрсөн үе, зарим философичдын тодруулан хэлснээр XIII зуунаас XX зууны 20-иод онд хамаатах мэт боловч үнэндээ цаг хугацааны хувьд ч, нийгмийнхээ агуулгын хувьд ч үүгээр хязгаарлагдамгүй.

Философийн шинжлэх ухааны доктор Ц.Гомбосүрэн Монголын феодалын байгуулал, феодализмд өмнөх судлаачдаас өөрөөр хандаад зогсохгүй, бүхэлд нь эргэлзээ төрүүлснээрээ сонин юм. Тэр “нийгэм [улс], иргэншил хоёрын холбоо ба ялгааны тухай ийм ойлгоцныхоо үүднээс Монголын уламжлалт нийгмийг тодруулж өгүүлбэл XIII зууны эхнээс XX зууны 20 – иод он хүртэл үеийн Монголын эдийн засаг, нийгмийн бүтэц ба нийгмийн харилцаа, төр, оюун санааны амьдрал зэргийн бүрэлдэл ба өөрчлөлтийг авч үзвэл энэ нийгмийг феодалын нийгэм хэмээж болмооргүй санагдаж байгаа юм “ гэжээ. Доктор Ц.Гомбосүрэн Баруун европын Англи, Бельги, Шотланд, Франц, Итали, Нидерланд зэрэг орнуудад тогтсон сонгодог феодалын нийгэм дэх зайлшгүй шинжүүдийг “түүхэн жишилтийн аргын дүрэм, шаардлагуудыг чанд баримтлаад” бүтэц ба үйлийн төсөө, ялгааг харьцуулаад иймэрхүү санаанд хүрсэн бололтой...

...Доктор Ц.Гомбосүрэн цааш нь монголын хувьд мал сүрэг чухал, гэхдээ феодалууд гар хоосон ардуудад мал сүргээ хариулгадаггүй, харин чинээлэг хэсэг нь ядуусаа ашигладаг байсан, мөн газрын хувьд бол өмчлөл, эзэмшил, ашиглалт гэсэн хэлбэрүүд байснаас бэлчээрийн онцлогоос шалтгаалан газар эзэмшил нь Монголын нийгэмд онцгой үүрэгтэй гэж үзээд, нэгд, XIII зуунаас XX зууны 20-д он хүртэл манайд оршин тогтнож ирсэн нийгмийн тогтолцоо бол бэлчээрийн газар эзэмшлийн хамжлагат нийгэм байлаа. Хоёрт, энэ нийгмийн хувьд эдийн засгийн үндэс нь улс орны нийт газрыг эзэн хаан буюу төр өмчилж, ноёд, тамгатай хутагт нар хууль цаазын дагуу өв залгамжлан хувьдаа эзэмшдэг байв гэсэн хоёр ерөнхий дүгнэлт хийжээ.

Ийнхүү доктор Ц.Гомбосүрэн газар өмчлөлийн Феодализмийн оронд бэлчээр эзэмшлийн хамжлагат нийгмийг гарган ирсэн нь танин мэдэхүйн хувьд сонирхолтой бөгөөд шинэлэг талтай. Гэхдээ Монголын нийгмийг өөрөөс нь, ядаж дорно дахиных нь талаас, үндэс ёзоороос нь биш, баруун европын улсуудаар жишилт авсан, зохиогчийн зарим санаа нэг нь нөгөөгөө дэгээгдсэн мэтээс үзэхэд эцсийн үнэн гэхэд эргэлзээтэй санагдана. Эндээс далим аваад, жаахан түрүүдэд хэлэхэд монголд феодализм XX зууны хориод онд ч, ардын засгийн жилүүдэд хамжлагын харилцааг халснаар ч, түүгээр ч үл барам социализмын үндсийг байгуулснаар ч төгсгөл болоогүй. Мөн чанартаа социализмын гэгдэх үед ч ажилчид хөдөлмөрийн дэвтэрийн тасралтгүй бичилтийн, малчид хөдөөний паспортын дэглэмийн, сэхээтнүүд анкет бүртгэлийн хамжлагын харилцаанд байж л байсан. Энэ утгаараа Монголд социализм бус, харин М.С.Восленскийн оросын нийгэмтэй холбогдуулан онож хэлснээр “бодит социализм” бол төрийн (улсын) монопольт феодализмын байгуулал л байсан билээ.

Гуравдугаарт, Хорьдугаар зууны Монголд социализм байсан эсэх нь маргаантай ч, захиргаадлын хүнд сурталт – тоталитари тогтолцоо байсан нь ямар ч маргаангүй. Нийгмийн давхраажлын үүднээс үзвэл захиргаадлын дэглэм нь эрх баригчдын албан тушаалын шатлал, зэрэг дэв, цол хэргэм, зиндааг зориуд олон болгодог, нийгмийн бодит давхраажлыг зохиомлоор өндөрсгөдгөөрөө онцлогдуу болно.

Миний төсөөллөөр Монголд тоталитари тогтолцоо бүрэлдэх хоёр шимт хөрс байсны нэгдэх нь дорны деспотизм, нөгөө дэх нь хүй элгэний хийгээд нэг нутаг усныхны социализм юм. Ерөөсөө Дорно дахины ард түмэн өрнөдийнхөөс нэлээд ялгаатай. К.Маркс нэг л удаа хэрэглэсэн “Азийн үйлдвэрлэлийн аргадаа” дорно дахинд төр нь газар өмчилдгийг, тэрхүү төрдөө ард түмэн нь дуулгавартай нь аргагүй захирагдан бөглүүхэн амьдардгийг анзаарчээ. Харин германы харьцуулсан социологич К.Виттфогель олныг шуугиулсан “Дорнын деспотизм” \1957\ ном бичсэн бөгөөд “усан шахуургат” нийгмийг томъёолсон. Үнэндээ манайд гол мөрөн ховор, голдуу хойшоо урсгалтай, гэхдээ ган гачиг, зуд турхан тохиолдож, “усан шахуургыг” өөрийн эрхгүй сануулна.

Тоталитар дэглэмийн үндсэн шинжүүдийг Фридрих \1954\ 1. Хотлоор нь хамарсан үзэл суртал, 2. Гол төлөв нэг дарангуйлагч захирдаг, үзэл сурталдаа чин үнэнч нэг нам, 3. Нууц цагдалтын төгөлдөржил, 4. хүчний бүтэц, эдийн засгийн байгууллагыг хүртэл оролцуулсан бүхнийг хянасан төрийн хяналт гэж ангилжээ. Сүүлд үүнийгээ 3.Бзеженскийн хамт 1. Үзэл сурталыг өргөн хэрэглэх 2. Нэг намын тогтолцоо , 3. Аллага, хядлага, 4. Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хяналт, 5.Зэвсэглэлийн хяналт, 6. Эдийн хяналт гэж нэмж өөрчилсөн юм.

XX зууны Монголд эхлээд нэг хүний буюу Х.Чойбалсангийн, дараа нь бичил бүлгийн буюу Ю.Цэдэнбал тэргүүтэй МАХН-н Төв хорооны Улс төрийн товчооны гишүүдийн дарангуйлал тогтож, тэр нь 1990 оны ардчилсан хувьсгалын эхэнд унасан билээ. Социализм бодит байдал болсны хувьд тухайн цагтаа Москвагийн Ломоносовын их сургуулийн багш байгаад ХБНГУ-д цагаачлан гарч, тэрслүү үзэлтэн гэгдэж явсан философын ухааны доктор, зохиолч А.А.Зиновьев маш сонин бөгөөд даацтай санаа дэвшүүлэн тавьсан юм. Түүнийхээр бол орос оронд коммунизм бодит байдал болон хувирсан нь Марксизмаас түүгээр ч зогсохгүй В.И.Лениний большевик намаас төдийлөн хамаараагүй, харин оросын ард түмний түүх, оросын нийгэм үндэс язгууртай хүйн холбоотой ажээ. Тэр нь зөвхөн октябрийн хувьсгалаар хязгаарлагдахгүй, харин оросын түүхийн угсаа гарвал, удам угшил, дотоод логикоор урт удаан хугацаанд бэлтгэгдсэн, нөхцөлдсөн, зайлшгүй зүй тогтлын шинжтэй гэнэ. Түүний язгуур үндэс оросын нийгэм дэх хүй нэгдэл болно. А.А.Зиновьев дэлхийн улс түмнийг 1. Ажилсаг, 2. Харилцамжсаг бүтэцтэй гэж хуваагаад нэгдэх бүтэцд хамаарагдах нийгмүүд зах зээлийн, хоёр дахид хамаарагдах нь солиализмын замаар орсон гэжээ. Өнөөдөр социалист байсан орнууд тэрчлэн БНХАУ, БНСВУ аль хэдийнээ, тэгэхдээ нэг их сүр дуулиан бололгүй, чимээгүйхэн зах зээлийн орон болчихжээ. Үүний учир нь тухайн ард түмнүүдийн угийн ажилсаг, хөдөлмөрч шинж юм. Гэтэл оросууд, ялангуяа манайхан болохоор эрийн гурван наадам, найр цэнгүүн, ой хурим, элдэв нийллэг зэргийг урьдал болгодог. Садан төрөлсөг, айл аймагсаг. Ажил хэргийг цагаар бус, өдөр хоногоор баримжаалдаг зэрэг нь эхний бүлэгт багтдаг улс түмнүүдээс ихээхэн ялгаатай.

Коммунлаг буюу харилцамжсаг нийгмийг, түүнд заяамал, зуршмал суурь шинжүүдийг А.А.Зиновьев “коммунлаг шинж”, “коммуны эгэл ба бэрх бодгаль”, “коммуны харилцаа”, “коммуны зан үйл” зэрэг ойлголтын үндсэн дээр тайлбарлажээ. Түүний өгүүлснээр коммунлаг, манайхаар бол хот айлархуу шинж гэвэл: “Нийгэм гэж хэлж болохоор хүмүүсийг нэгтгэн цуглуулсан тэр газар харилцамжсаг байдлын хууль газар сайгүй нэг. тэдний хуулиуд тун энгийн, юутай ч болов нийтэд илэрхий, нийгмийн гишүүдийн олонхид тодорхой. Хэрвээ тиймэрхүү байгаагүйсэн бол нийгмийн амьдрал нь өөрөөр байхын аргагүй. Ийм хуультай нийгэмд аж төрж байгаа хүмүүс тийм хуультайгаа ухаарахаас яахав. Тэд удаан хугацааны туршид нэгэн хамтлаг болж, тэгж л юмуу арай өөрөөр амь зууна. Хүмүүсийн нэг нь нөгөөтэйгөө харьцах харилцаа (үйлдлэг, сэдлэг) нь харилцамжийн хуулийн мөн чанар, тодорхой дүрмүүд болно. Тэдний хувьд түүхийн явцад нарийссаар бий болсон, хүмүүс бүлгүүд өөрсдийгөө л хамгаалахаар дандаа тэмүүлдэг, нийгмийнхээ тухайн ахуйд л өөрийн оршин байх нөхцөлөө сайжруулдаг. Жишээлэхэд бага өгч, их авах; бага эрсдэл гаргаж, том юм унагах; өчүүхэн хариуцлага хүлээж, их хүндлүүлэх; бусдаас өөрийгөө ялигүй хамааралтай байлгах; зэрэг горим дүрэмтэй.” Тэдгээр нь зуун зуунаар сунгагдана. Энэ мэтчилэн коммуны эгэл ба бэрх бодгаль, харилцаа, зан үйлийн тухай өгүүлж болох авч, цаг алдаж, зай авах тул орхиё.

Дөрөвдүгээрт: “нэг улс – хоёр иргэншил” тогтолцоо бол XX зууны Монголын нийгмийн хөгжлийн гол үр дүн, тодорхойлогч шинж мөн. Энэ тухай хэдэн жилийн өмнө молхи миний бие МАХИ-н цагаан байшинд болсон нэгэн эрдэм шинжилгээний ярилцлага дээр анх сэдсэн ухаантай . “Нэг улс-хоёр байгуулал” -ыг илт хуулбарласан мэт санагдана. Агуулгаараа бол үзэл баримтлалаар тогтохгүй, түүнээс хальсан номлолын шинжтэй юм. Түүнийг нийгмийн давхраажлын судалгаанд эрх биш харгалзан үзүүштэй.

Орчин үеийн улс төрийн судлалд зарим хувьсгалыг “галт уултай”, заримыг нь “эрдэнэсийн эрэл”-тэй зүйрлэсэн нь бий. Тэгвэл Бээжин хотноо 1984 оны VI сарын 22-23-нд Гонконгийн үйлдвэр худалдааны төлөөлөгчтэй болон нийгмийн нэрт зүтгэлтэн Жун Шиюньтэй Дэн Сяопин уулзахдаа “нэг улс – хоёр байгуулал” томъёоллоо анх нийтэд тунхагласан. Мөн оны хуучаар Их Британы ерөнхий сайд “төмөр” хатагтай хэмээн цууд гарсан М.Тэтчертэй ярилцахдаа үүнийгээ дахин

нотолсон билээ. Энэ бол хятадын бодит байдлаас урган гарсан гэх, хятад хүний нарийн ухаан, торгон санаа байсан юм. Үнэхээр хятадын ард түмэнд нуугдаж байсан “эрдэнэсийг” Дэн Сяопин нээж, үүгээрээ өмнөд хөршийн агуу их удирдагчаар тодорсон билээ. Түүний тухай академич Д.Цэдэнсодном гуай бидэнд: “Соёлын хувьсгалын” үед Жоу Энх Лайг эмнэлэгт хэвтэж байхад нь Батлан хамгаалах яамных нь сайд нэгэн нөхрийнхөө хамт Ази хүний хувьд нэг жин давжаа алимтай түүнийг эргэжээ. Тэгэхэд Жоу Энх Лай нөгөө давжаа алимнаас нэгийг барьчихаад, нууцаар яриа чагнагч тавьчихсан байж магад гэж болгоомжлоод “Бид их санаад юухэв, энэ л давжаа алимыг ургуулчихвал боллоо боллоо” гэж хэдэнтээ давтахад нь нөгөө хоёр Дэн Сяопиныг (Сяопин гэдэг нь давжаа алим гэсэнтэй дүйх утгатай үг) даруйхан суллах учиртайг ойлгосон гэдэг шүү” гэж нэгэн сонин зүйлийг хуучилсан билээ. “Соёлын хувьсгалын” самуун, хятад хүний дотуур тамир гэж үнэхээр гайхмаар.

Уг нь “нэг улс- хоёр иргэншил” зээлдсэн санаа биш, ургуулан бодсон зүйл. Гэтэл философийн шинжлэх ухааны доктор Г.Чулуунбаатар энэ тухай хэд хэдэн сонирхолтой өгүүлэл нийтлүүлснийг эс тооцвол манай нийгэм судлаачид энэ талаар дуугаа хураасан мэт байгаа нь сонин. Зүй нь энэ талаар нухацтай ярилцаж, санаа оноогоо нэгтгэж, төрийн бодлогын чинээнд хүртэл өргөмөөр байгаа юм. Доктор Г.Чулуунбаатар “Нэг улс- хоёр соёл иргэншил: өчигдөр, өнөөдөр, маргааш,” гэсэн бэсрэгхэн хэрнээ чамбай өгүүлэлдээ “нэг улс- хоёр соёл иргэншил” -н тогтолцоо нь нэрийн хувьд шинэвтэр хэдий ч бодит байдлын хувьд урьдын гэх урт намтартай, өнөөгийн гэх бодит дүр төрхтэй, ирээдүй гэх заяа төөрөгтэй бүхэл бүтэн ард түмний амьдралын нэгэн төрлийн цогцлол мөн”. Нүүдлийн соёл иргэншлийн ерөнхий суурин дээр нэг тусгаар улсын хүрээнд соёл иргэншлийн хоёр том түүхэн хэв маяг зэрэгцэн оршиж, харилцан нөлөөлж ирсэн олон зуун жилийн түүхийн явцад Монгол улсын нутаг дэвсгэр дээр төр - иргэншлийн нэгэн өвөрмөц тогтолцоо бүрэлдэн бий болжээ. Үүнийг иргэншлийн хандлагын үүднээс бол соёл иргэншлийн Монгол хэв маяг, нийгэм - улс төрийн үүднээс бол “нэг улс - хоёр соёл иргэншил” тогтолцоо гэж нэрлэж буй болно гэжээ.

Доктор Г.Чулуунбаатар бид хоёрын гар эрдэм судлалын ажилд нийлдэг ч “нэг улс- хоёр соёл иргэншил” бол нэгд, түүнийг олон жилийн үүх түүхтэй гэдэгтэй, хоёрт, нийгэм- улс төрийн утгаар гэсэнтэй санал зөрж байна. Чухамхүү хорьдугаар зууны монголын түүхэнд, бүр тодруулж хэлбэл сүүлийн дөчөөд жилд нэг талаас үйлдвэржиж, нөгөө талаас хот суурин байгуулагдсанаар л манай улсад хоёр иргэншил бодитойгоор зэрэгцэж, зуузай холбосон. Тэр битгий хэл хотын иргэншил давамгайлах амиатай болчихсон. Энэ бол яахын аргагүй бодит байдал. Харин сүүлийн жилүүдэд шилжилттэй уялдан, зарим нэг талаараа хотшил, эдүгээжил саарсан, саатсан, гэхдээ л өнөөгийн Монгол орон “мал-зэс буюу алт- зээл тусламж” гэсэн гурван “халимыг” зайдагнаж байгаа нь илэрхий.

Өдгөө хөдөөний хүчинд хот оршин тогтнож, манай ганзагачдын санхүүжилтээр өмнөд хөршийн Эрэн хот байгуулагдаж байна гэвэл нэг их хэтрүүлэг болохгүй биз ээ. Манай улсад хоёр иргэншил бодитойгоор зэрэгцэж буй нь бус, харин цөөнгүй тохиолдолд хөдөөгөө хот нь монжиж, элдвийн ченжүүд нь хөлжиж байгаа нь гайхалтай агаад гажигдуу.

Үйлдвэржилтийн өмнөх хийгээд түүний дараах, өөрөөр хэлбэл хот, хөдөөний нийгмийн талаар германы социологич Ф.Теннис \1955-1936\ социологийн шинжлэх ухааны ойлголтын аппаратын бүрэлдэхүүнд “Нийтлэг” \Gemeinschaft\, “Нийгэм” \Gesellschaft\ ухагдахууныг оруулан, тэр хоёрын адилсал ба ялгааг дараах байдлаар тодорхойлжээ. Жишээлбэл:

1. Хэрвээ бодгалийн сэдлийн тухай ярих юм бол “Гемайншафт” –д хүйн зарчмыг удирдлага болгон, тариа ногоо хураахад бие биендээ үнэ хөлсгүй тусалдаг, харин “Гезельшафт” –д хувь хүний сонирхлыг зохистойгоор харгалзан үзэх үндсэн дээр, ажил хэрэгч байдлаар бие биендээ харилцан туслалцаж, тодорхой бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ төлбөрийг хийцгээдэг.
2. “Гемайншафт”-д нийгмийн хяналт нь ёс заншил, шашин шүтлэг, бичигдсэн ба бичигдээгүй хуулийн хүрээнд тавигддаг бол “Гезельшафт” –д албан ёсны эрх зүйгээр зохицуулагдана.
3. “Гемайншафт” хэв шинжийн нийгэмд хөдөлмөрийн хуваарь гол төлөв садан төрлийн холбоо сүлбээгээр нөхцөлдөн, хязгаарлагдмал байдлаар төрөлжиж, ахуйдаа эрэгтэй, эмэгтэйчүүд,

хүүхдүүд тодорхой үүргийг гүйцэтгэдэг. Харин “Гезельшафт” –д айл гэр дэх үүргээс мэргэжлийн үүрэг салан, нарийн мэргэшдэг.

4. “Гемайншафт” хэв шинжийн нийгмийн соёл шашны үнэт зүйлс дээр, харин “Аезельшафт”-д иргэний эхлэл дээр үндэслэдэг.
5. “Гемайншафт” нийгмийн гол байгууламж нь айл гэр, хөрш байдаг бол “Гезельшафт”-ынх томоохон нийгэмлэг байгууллагууд (ажил хэргийн хүрээлэл, төр засаг, улс төрийн нам, сайн дурын нийгэмлэгүүд) байдаг болно.

Ф.Теннисын ангиллыг нэгд, хэтэрхий хялбар бөгөөд хоёрчилсан, хоёрт, аливаа нийгэмд тохиолддог зөрчилдөөн мөргөлдөөн, хямралыг тооцоогүй хэмээн шүүмжилдэг ч, сургалт- судалгааны ажилд өнөө хэр нь ашигласаар ирлээ.

Тавдугаарт : XX зууны монголын нийгмийн хөгжил нь тус улсын тусгаар тогтнолтой үлэмж холбоотой. Хорьдугаар зууны эхэнд одоогийн монгол улс Манж Чин улсын *колоницлолд* байсан нь нийтэд илэрхий, Манжууд манайхыг болон хятадыг эзлэн захирч, колончилж ирсэн мөртлөө өөрсдөө хятад үндэстний хувьд уусан шингэж, харин монголчууд үндэстнийхээ бие даасан байдлыг хадгалан үлдээд зогсохгүй, тусгаар тогтнол юугаа сэргээж чадсан юм. Үүнтэй холбогдон Монгол улс Манж Чин улсын колоницлолд байсан уу? Эсхүл хоолбооны улсын хэр зэргэмжтэй байсан уу? гэсэн ацан асуудал сөхөгдөж, судлаачдын сонирхлыг татах болжээ. Манжууд манай улсыг эрхшээлдээ оруулаад зарим зүйлийг, ялангуяа төрийн байгууламжийг нь нэлээд хэмжээгээр хэвээр нь үлдээж, түүнийгээ эзэнт гүрний эрхт ашигт ч эзэмшлийн бүрэлдэхүүн хэсэг хятадын хувьд баримтлах бодлого, хэрэгжүүлсэн арга хэмжээнүүддээ ч чадмаг ашиглаж байсан нь нууц бишээ. Хэрэвээ хятадад нийтийг хамарсан үймээн самуун дэгдвэл дайнч уламжлалтай монголын хөнгөн морин цэрэг аминд орохыг нэг талаас бодолцсон, мөн түүнээс дутахааргүй монголчууд нэгдчихвэл эзэн хаантайгаа тэрсэлдэн тэмцэлдэхийг ч мэдэж байсан. Тийм учраас Баруун Монголчууд, ялангуяа Өөлдүүдийг тараан нутагшуулж, генетикийн голомтуудыг бий болгосон бол Дарьганга хошуу мэтийг байгуулан, хаалт жийргэвчийг байгуулсан түүхтэй. Тэдгээр нь 1911 онд монгол улсад үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн өрнөж, тусгаар тогтнолоо сэргээхэд нааштайгаар нөлөөлсөн ч бүрэн эрхт тусгаар улс болох гай барцадыг нимгэлж чадаагүй, харин ч хоёр их гүрний улс төрийн наймааны гол хөзөр болсон юм.

XX зууны эхэн үеийн монгол орон дэлхийн том улс гүрний ашиг сонирхлын бүсэд татагдан орсон ч, шийдвэрлэх хэмжээгээр агуу их хоёр хөршөөс хамаарч байлаа. Тиймээс өнөөгийн монгол улсад нэг бол “чонын амнаас гараад барын аманд орох”, эсхүл хойд хөршөө тууштай түшиж, тусгаар тогтнолоо олохоос өөр сонголт байгаагүй, зэрэгцээ хувилбар ч байгаагүй. Харин аар саархан тактикийн шинжтэй зүйлс байсныг үгүйсгэх аргагүй. Үүнтэй таширлуулан би хэлмэгдүүлгийн зайлшгүйг цагаатгах утгаар нь бус, харин тусгаар тогтнолын өр төлөөс утгаар нь зориуд онцлон тэмдэглэж байна.

XX зууны монголд гурван хувьсгал тохиосны нэгдэхийнх нь үр дүнд тусгаар тогтнолоо сэргээсэн, хоёр дахийнх нь үр дүнд түүнийгээ баталгаажуулсан, одоо гурав дахийнх нь нүүрэнд сэргэсэн мандлын гараан дээр ирээд байна. Түүх зөвхөн өнгөрсний илэрхийлэл төдий бус, бас дахин давтагдахын, сургамж авахын урьдчилгаа юм. Ирэх зуун Монголын нийгмийн хувьд өнгөрөн зууныхаас огт дутахааргүй адармаатай, хүнд хэцүү шалгалт сорилттой тулгарахыг үгүйсгэх аргагүй. Тийм учраас XX зууны монголын нийгмийг социологийн үүднээс тун нарийн судлууштай байгаа юм. Үнэндээ бол хорьдугаар зууны монголын нийгмийг түүхийн үүднээс, тэгэхдээ мушгин гуйвуулсан байдлаар нэлээд судалсан, харин социологийн үүднээс бараг судлаагүйг онцгойлон дурьдалтай.

1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн Хиагтын гурван улсын хэлэлцээрээс эхлээд, хориод он гэхэд бүрэн мухардалд орж, гадны зэвсэгт хүчний нөлөөгөөр автономитоо алдах юмуу тоглоомын засгийн газар байгуулахаас хэтрэхээ больсон билээ. Харин 1921 он Ардын хувьсгал тусгаар тогтнолоо олон улсын түвшинд хүртэл баталгаажуулсан ч дотооддоо хувьсгалын эсэргүү явдалтай тулгарч, удаа дараагийн ордны эргэлтийн явцад номенклатурчдын засаглал тогтсон юм. Гэхдээ энэ нь Коминтерний хувьсгалын экспортчилал төдийхөн биш, манай нийгэм, төр засгийн

түүхэн замнал, хамгийн гол нь монгол хүний, ялангуяа төрийн түшээд, албан хаагчид, улс төрчдөөс угшилтай, үүдэлтэй болно. Үүний нэг эх сурвалж нь Манжийн үеийн “конфедерализм” байж тун болзошгүй.

Орчин үеийн улс төр судлалын ойлголтоор бол “Федерализм” нь явцуу утгаараа янз бүрийн түвшний засаглалын харилцаа, өргөн утгаараа үндсэн хуулиар зөвшөөрөгдсөн оролцоо ба өөрөө удирдах ёсны хослол юм... Хэдийгээр монгол туургатан, ялангуяа Ар монгол Манжийн колончлолд 220 жил болсон ч төр ёсны уламжлал, үндэсний цөөнхийн тусгаарлагдмал байдал, эдийн засгийн үндсээ бараг хэвээр нь шахам авч үлдсэнээрээ онцлог юм. Мөн газарзүйн байршлын хувьд хоёр их гүрний бамбай бүс байсан явдал колоний ч, тусгаар тогтнолын ч багагүй учир холбогдолтой. Гэвч Монгол улс тусгаар тогтнолоо сэргээнгүүтээ бие даан хөгжих чавдаргүй байсан юм. Энэ утгаараа Монгол улс эдийн засгийн болоод улс төрийн хувьд дагуул юмуу хараат байдалд өөрийн эрхгүй оруулж байсан, тэр нь бараг XX зууны туршид үйлчилсэн онцлогтой.

Зурагдугаарт: XX зууны Монголын иргэний нийгэм ихээхэн солгойдуу байлаа. 1921 оны өмнөх Монгол бол бүхэлдээ, хотлоороо шашны нийгэм байсан, харин түүнээс хойшихыг юу гэж нэрлэх, ямар ангилал бүлэгт, багтаах нь шаггүй төвөгтэй. Миний ойлголтоор бол хуарангийн нийгэм гэлтэй. Ингэж хэлэхдээ захиргаадлын жилүүдийн монгол улс хэр чинээнээсээ давсан цэрэгжсэн улс байснаар нь биш, ерөөсөө түүний дотоод харилцаа, амьдралын хэв шинж, аж төрөх ёс туушдаа, хавтгайдаа хуаранжсан байсан юм. Сургуулийн сурагчид дотуур байранд сууж, боловсрол эзэмшиж байсан, тэр нь анхдагч хуаран. Хөдөөнийхөн нийгмээс хашаа хэрмээр тусгаарлагдаагүй ч паспортын дэглэмд баригдаж, зам явахаар хязгаарлагдаж байлаа. Хотын ажилчин, албан хаагчид адаглаад иргэний хамгаалалтын дэг горимд, нийтийг хамарсан үзэл суртлын цагдалтын дор ажиллаж, аж төрж байлаа. Өнөө хүртэл Улаанбаатар төмөр замаас авхуулаад хагас цэрэгжсэн иргэний, аж ахуйн байгууллагууд байсаар л байна. Тэдгээр дээр шорон, засан хүмүүжүүлэх байгууллага, хаяг тогтоох ба эрүүлжүүлэх байрууд нэмэгдэх нь эргэлзээгүй.

Тэгшитгэсэн цалин хөлс, өргөн хэрэглээний бараа хомсдол, байнгын оочир дугаар бол саяхны манай дүр зураг, хуарангийн ердийн амьдрал байсаан. Гагцхүү ерөн оны цагаан морин жилийн ардчилсан хувьсгалын үр дүнд монголын ард түмэн эрх чөлөөний замд орлоо. Ардчилал мөрөөдөл бус, бодит зүйл боллоо. Гэвч манай нийгэмд бүтцийн хямрал ужгирч, шилжилт удааширч байна. Ядуурал, ажилгүйдэл нүүрлэж, гэмт хэрэг өсч, эрүүгийн нөхцөл байдал хүндэрсний харгайгаар нийгэм хүчний бүтэц, хатуу гарыг санагалзаж, нүдний өмнө цагдаажсан орон болсоор байна. Ийм нөхцөлд монголын нийгэм зах зээлийн орнуудын нийтлэг жишгийн бус, харин өвөрмөц, гажиг, сондгой байдлаар давхраажих нь илүү магадлалтай, үнэний хувьтай. Үүний учир шалтгаан бусдаас, гадныхнаас бус, чухамхүү биднээс, монголын нийгмийн өнөөгийн нөхцөл байдлаас л өмнөтгөл, үүдэлтэй.

Ерээд онд монголд зөвхөн ардчилсан хувьсгал тохиогоогүй, бас үймсэн олны болон номенклатурын хувьсгал зэрэгцэж, гурамсан, гурвалсан хувьсгал болсон юм. Тэр гурвын сэлгэлт, шилжилт, хувирал, өөрчлөлт, хувьсгал, эргэлт, өгсөлт уруудалтаар өнөөдрийн, XX зууны шувтаргын манай нийгмийн хөгжил тодорхойлогдож байна. XXI зууны гараа ч доторхой хэмжээгээр хамаарна.

Хорьдугаар зууны түүхэн хөгжлөөр бэлтгэгдсэн, түүгээр нөхцөлдсөн ардчилсан хувьсгал нь *импортын*, үймсэн олны хувьсгал нь *дарвины*, номенклатурын хувьсгал нь хоёрдугаар *цувааны* гэмээр содон шинжтэй. Содон шинж бүдгэрэх үү эсвэл улам тодрон шийдвэрлэгч, тодорхойлогч болох уу гэдэгт хараахан хариу олдоогүй байна. Харин доктор (Ph.D) Б.Даш-Ёндон философичийнхоо зангаргаар “Улс орны сайн сайхан, түүний бүрэн бүтэн байдал, үндэсний ашиг сонирхлын төлөө тэмцэл ардчилсан аргаар явагдах ёстой. Ард түмнийг энэ үйлсэд өргөнөөр оролцуулахын тулд улс оронд ардчиллыг хөгжүүлэх ёстой. Харин энэ нь *демократаас охлократи* болон хувирах ёсгүй. Тийм хувирал явагдах нь (одоогоор яг тийм байна) ардчиллыг хэврэг болгох осолтой” хэмээн сэрэмжлүүлжээ. Өдгөө монголд ардчилал нялх байна, хэврэг байна. Харин түүнийг буцааж ухрааж, эрчийг нь хариулж болохгүй. XX зууны монголын нийгмийн өвөрмөц онцлог, язгуур төрхийн талаар багцалж хэлэхэд иймэрхүү байна. Эдгээрээс аль нэг хандлагыг нь дөвийлгөж, туйлшруулж болохгүйн нэгэн адил бас бүрхэгдүүлэн замхруулж таарахгүй. Тэгвэл монголын нийгмийн судалгааны арга зүйн суурь хандлага хазайж, түүнийгээ дагаад давхраажлын судалгаа будлиантах, улаан шугамнаасаа хазайх, арга яс нь гулзайх тун чиг болзошгүй.